



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 4/᠒᠔8

Мандалговь

Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн шинэчилсэн
бүртгэл, техникийн хяналтын үзлэг
тооллого, албан татвар, төлбөр хураах тухай

Монгол Улсын Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 8-р зүйлийн 8.2 дахь заалт, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9.3 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 12.1.3 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 7.1.2, 17.1, 17.2, 17.4, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.1, 10.1.7, 10.1.8 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 213 дугаар тогтоол, Сангийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2017 оны 01 сарын 30-ны өдрийн 34/19 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Дундговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага, иргэдийн эзэмшилд байгаа бүх төрлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл, албан татвар, төлбөр хураалтыг 2018 оны 03 дугаар сарын 01-нээс 2018 оны 06 дугаар сарын 01, техникийн хяналтын үзлэг оношлогоог 2018 оны 03 сарын 01-нээс 2018 оны 12 сарын 20-ны хооронд зохион байгуулсугай

Хоёр. Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл, албан татвар, төлбөр хураах, техникийн хяналтын үзлэг явуулах комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл, тооллого, албан татвар, төлбөр хураах, техникийн хяналтын үзлэг явуулах хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн авто зам ашигласны төлбөрийн төлөлтөд тээврийн хэрэгсэл эзэмшигчдийг бүрэн хамруулж улс орон нутгийн орлогод төвлөрүүлэхийг Татварын хэлтэс /М.Туяацэцэг/ үүрэг болгосугай.

Дөрөв. Орон нутгийн замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүдийг автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, төлбөрийг

᠒᠒᠒᠒3᠙᠖

төлсний дараа техникийн хяналтын үзлэгт хамруулах, улсын дугаар олгох, улсын дугаарын давхардлыг арилгахыг Автотээврийн төв /Ц.Бямбацогт/-д үүрэг болгосугай.

Тав. Тээврийн хэрэгслүүдийг хянан шалгаж автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлбөр төлөөгүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, албан журмын даатгал төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигчийг хуулийн дагуу хянан шийдвэрлэхийг Цагдаагийн газар /М.Ганбаатар/, Автотээврийн төв /Ц.Бямбацогт/-д үүрэг болгосугай.

Зургаа. Нутаг дэвсгэртээ байгаа автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны төлбөрийг төлүүлэх, бүртгэл тооллого, хяналтын улсын үзлэг явуулах бэлтгэлийг хангуулах, тээврийн хэрэгсэл бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий салбар комиссыг байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Долоо. Техникийн хяналтын үзлэг болон татварын мэдээг сар болгоны эцсээр гаргаж комиссын даргад мэдээлж байхыг Автотээврийн төв /Ц. Бямбацогт/, Татварын хэлтэс /М. Туяацэцэг/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

Аймгийн засаг даргын 2018 оны 03 дугаар
сарын 13-ны өдрийн 1/03 дугаар
захирамжийн 1-р хавсралт

АВТОТЭЭВЭР БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ, АЛБАН ТАТВАР,
ТӨЛБӨР ХУРААХ, ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:	А. Ганбат /Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга/
Нарийн бичиг:	М. Туяацэцэг /Татварын хэлтсийн дарга /
Гишүүд:	М. Ганбаатар /Цагдаагийн газар дарга/ Ц. Бямбацогт /Автотээврийн төвийн дарга/ Н. Энх-Амгалан /Замын цагдаагийн тасгийн дарга/ Н. Батчулуун /Техникийн хяналтын үзлэгийн инженер/ Ч. Оюунжаргал /Орлогын тасаг ТУБ/ М. Эрдэнэ-Очир /Автотээрийн хэрэгслийн хяналтын улсын байцаагч/ Э. Болормаа /Автотээрийн хэрэгслийн хяналтын улсын байцаагч/ Г. Анхбат /Албан журмын даатгалын холбооны салбарын менежер/

Аймгийн засаг даргын 2018 оны 03 дугаар
сарын 13-ны өдрийн 4/108 дугаар
захирамжийн 2-р хавсралт



АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ, АЛБАН ТАТВАР, ТӨЛБӨР ХУРААХ,
ТЕХНИКИЙН УЛСЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ХУВААРЬ

1.Төвийн бүс:

1. Аж ахуй нэгж байгууллагууд	01 сарын 23-02 сарын 10
2. Төсөвт болон ТББайгууллагууд	02 сарын 13-24
3. Нийтийн такси үйлчилгээ	03 сарын 02-17
4. Сайнцагаан сумын 1-9-р багууд	03 сарын 20-03 сарын 31, 05 сарын 15-31

3.Зүүн бүс: /сумдууд/

1. Дэлгэрцогт	04 сарын 02-04
2. Дэрэн	04 сарын 05-07
3. Цагаандэлгэр	04 сарын 08-09
4. Говь-Угтаал, уурхайнууд	04 сарын 10-12
5. Баянжаргалан	04 сарын 13
6. Уурхайнууд	04 сарын 14
7. Өндөршил	04 сарын 15-17
8. Гурвансайхан	04 сарын 18-19
9. Мөнгө, Лог, Хөөт г.м уурхайнууд	04 сарын 20
10. Өлзий	04 сарын 21-23

2.Баруунбүс: /сумдууд/

1. Луус	04 сарын 26-28
2. Хулд	04 сарын 29, 05 сарын 02
3. Дэлгэрхангай / Гөлтгөний уурхай/	05 сарын 03-05
4. Сайхан-Овоо	05 сарын 06-07
5. Эрдэнэдалай	05 сарын 08-13
6. Адаацаг	05 сарын 14-16